



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 527

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 32,962,300.00 (гучин хоёр сая есөн зуун зуун жаран хоёр мянга гурван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар сургуулийн захирал Б.Баясгаланмөнхөд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдаа ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн  
527 дугаар тогтоолын хавсралт

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ДАРХАН-УУЛ  
АЙМАГ ДАХЬ САЛБАР СУРГУУЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, АКТЛАЖ ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИН

Д/Д	Автомашины марк, улсын дугаар зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуриатлагдсан элэгдэл
				/төгрөг/
1	Ландровер- 62-63 ДАХ, суудал 2157957, Араг 591250	2000/2008	195000	18,962,300.00
2	Рекстон, 87-20ДАР, суудал, Арлын №-14Р-112833	2004/2012	170392	14,000,000.00
Нийт дүн				32,962,300.00
				(гучин хоёр сая есөн зуун жаран хоёр мянга гурван зуу)